

Монгол Улсын Үндэсний аудитын газар

ҮАГ

**УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

2005 оны 9 дүгээр
сар

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨШҮҮРЭГ ХЭРЭГТЭЙ БАЙНА**

**ХӨРӨНГИЙН БИРЖ, ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР
ТООЦОО, ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН
ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	1
	Аудитад ашигласан шалгуур	2
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	2
Аудитын дүн	1.Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал	3
	2.Хөрөнгийн бирж, ҮЦТТТХТ-ийн үйл ажиллагаа	13
Дүгнэлт		19
Холбогдох байгууллагын санал	Үнэт цаасны хороо	20
	Хөрөнгийн бирж ХК	25
	ҮЦТТТХТ ХХК	27
	ҮАГ-ын тайлбар	29
Зөвлөмж		32
Бусад	Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	33

Товчилсон үгс:

- ҮЦХ – Үнэт цаасны хороо
- ҮЦТХ- Үнэт цаасны тухай хууль
- ҮЦЗЗ- Үнэт цаасны зах зээл
- ТХШХ – Төрийн хянан шалгах хороо
- ТӨХ – Төрийн өмчийн хороо
- ТУЗ – Төлөөлөн удирдах зөвлөл
- МХБ ХК - Монголын хөрөнгийн бирж хувьцаат компани
- ҮЦТТТХТ ХХК – Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв хязгаарлагдмал хариуцлагатай компани
- БДК – Брокер, дилерийн компани
- АМСА – Арилжаа, мэдээлэл, судалгааны алба
- БХА – Бүртгэл, хяналтын алба
- ТТТХА – Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн алба
- УИД –Улсын их дэлгүүр
- ХОС- Хөрөнгө оруулалтын сан

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн төлөв байдалд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь дараахь чиглэлээр аудит хийж, дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөхөд чиглэгдсэн болно.

Үүнд:

- 1.Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал
 - а.ҮЦЗЗ-ийн тухай хууль, бусад эрхийн актын уялдаа холбоо, хэрэгжилт
 - б.Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал
- 2.Хөрөнгийн бирж, ҮЦТТХТ-ийн үйл ажиллагаа
 - а.Үнэт цаасны арилжааны зохицуулалт
 - б.Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа
 - в.Дотоод хяналтын тогтолцоо, үр нөлөө
 - г.Програм хангамж, мэдээллийн аюулгүй байдал
 - д.Санхүүгийн бүртгэл,тайлагнал

Аудитад Хөрөнгийн бирж ХК болон Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК болон ҮЦХорооны холбогдох зарим хэлтэс хамрагдлаа.

Аудитад Хөрөнгийн бирж ХК болон Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2004 оны болон 2005 оны эхний хагас жилийн төлөвлөгөө, тайлан, санхүүгийн баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, холбогдох бусад материалаас авсан мэдээлэл нотлох баримтад тулгуурлан ярилцлага хийх, тулган баталгаажуулах, түүвэр шалгалт хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын горимуудыг ашигласан болно.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур

Дараахь хууль эрхийн актыг аудитын шалгуурын эх сурвалж болгон ашиглалаа Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөрөнгийн бирж ХК-иар дамжуулан хийх захиалгат арилжааны журам
- Хөрөнгийн бирж ХК-ийн бүртгэлийн журам
- Хөрөнгийн бирж ХК-ийн үнэт цаасны арилжааны журам
- "ҮЦТТТХТ" ХХК-ийн Төлбөр тооцооны үйл ажиллагааны түр журам
- "ҮЦТТТХТ" ХХК-ийн Хадгаламжийн үйл ажиллагааны түр журам
- "ҮЦТТТХТ" ХХК-ийн Мэдээллийн бааз, сүлжээний ашиглалт, нууцлалын тухай журам

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг мөрдөж ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйл, холбогдох бусад мэдээллийг ажлын баримтад хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн дарга, тэргүүлэх аудитор О.Мэндбаяр удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Ц.Гэрэл, аудитор Г.Нямдорж нар 2005 оны 6 дугаар сарын 02-ноос 9 дүгээр сарын 23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Аудитад МУИС-ийн багш, Sc.Dr. С.Аюурзана шинжээчээр оролцов.

Аудитын дүн

Хөрөнгийн
зах
зээлийн
төлөв
байдал

1991 онд Хөрөнгийн бирж байгуулагдсан бөгөөд 2002 онд батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн дагуу “Хөрөнгийн бирж”-ийг Монголын хөрөнгийн бирж 100 хувийн төрийн өмчит ХК, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК болгон зохион байгуулжээ.

ҮЦЗЗ-ийн тухай хууль, бусад эрхийн актын уялдаа холбоо, хэрэгжилт

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд Үнэт цаасны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай хуулиуд мөрдөгдөж иржээ. Гэвч Үнэт цаасны зах зээлийн талаархи хууль тогтоомжийн заалт өөр хоорондоо зөрчилдөх явдал байна. Тухайлбал:

Үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлийн “ Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд нь андеррайтер, брокер, дилер, хөрөнгийн бирж түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, хөрөнгө оруулалтын сан байна”, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах Хөрөнгийн бирж, Дилерүүдийн арилжааны төв, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага, хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани байна” гэж заажээ. Гэтэл төрийн өмчийн хувьцаа, үнэт цаасыг худалдах үйл ажиллагаанд ТӨХ оролцож ирсэн нь хуулийн заалтуудтай зөрчилдөж байна.

Компанийн тухай хуулийн 35.1.4, 39.1-д зааснаар энгийн хувьцаа эзэмшигч нэмж гаргасан энгийн хувьцааг өөрийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй ч уг хуулийн 39.6-д “ХК-ийн хуралд оролцож байгаа, тухайн асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхиор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно” гэж зааснаар жижиг хувьцаа эзэмшигчид нэмж гаргаж буй хувьцаанаас авах эрхгүйгээр хуульчлагджээ.

Хувьцааны дундаж ханшийг, Тендер санал гаргахад ҮЦЗЗТХ-ийн 11. 6-д зааснаар Тендер санал гаргагчийн хувьцаа худалдан авахаар санал болгож буй үнийг тухайн хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, тендер санал гаргагч тухайн хувьцааг худалдан авсан хамгийн дээд ханш хоёрын аль өндрөөс доошгүй байхаар, төрийн

Аудитын дүн

өмчийн хувьцааг худалдахад Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоол, 2001 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасан “хувьчлалын шийдвэр гарахаас өмнөх 52 долоо хоногт хөрөнгийн биржээр арилжаалагдсан нэгж хувьцааных нь дундаж ханшаар”, хувьцааг хувь нийлүүлэгчдэд худалдан авахыг санал болгоход компанийн тухай хуулийн 58.1-д зааснаар “хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаар” гэж тогтоожээ. Иймд хувьцааны зах зээлийн ханшийг тогтоох аргыг нэг мөр болгох нь зүйтэй юм.

Компанийн тухай хуулийн 24.1-д компанийг өөрчлөн байгуулагдахын эсрэг саналтай байсан хувь нийлүүлэгч нь хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй, 24.2-д хувьцаагаа эргүүлэн авахыг шаардаагүй хувь нийлүүлэгчдийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлнэ гэж, 54.2-д хувь нийлүүлэгч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хяналтын багц хувьцааг хувьчилж авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй гэж заасан нь жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалсан ч, уг хуулийн 58.1 дэх заалт жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хямд үнээр цуглуулах боломжийг нээж байна.

Үүнээс гадна Компанийн тухай хуулийн 58.4-д “Хэрэв хувьчлалын үр дүнд хяналтын багцыг авсан бол 58.1 дүгээр заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал энэ хуулийн 54,55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана” гэжээ. Гэтэл 54 дүгээр зүйлд компанийг өөрчлөн байгуулах нөхцөлд л хувьцаагаа эргүүлэн авах эрх үүсэхээр заасныг үзвэл төрийн өмчийн хувьчлалын дараагаар компани өөрчлөн байгуулагдаагүй үед жижиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхгүй болжээ. Мөн хуулийн 54.4 дүгээр заалтаар эргүүлэн авах хувьцааны үнийг тогтоох эрхийг, хувьцааг авах гэж байгаа гол хувьцаа эзэмшигчдийн сонирхлын дагуу шийдвэр гаргадаг ТУЗ / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / - д олгосон нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд шударга бус болжээ. Түүнийг худалдах үүрэг хүлээсэн субъектээр зах зээлийн үнэ тогтоолгож буй энэ заалт уг хуулийн 56.1 дүгээр заалттай зөрчилдөж байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлд аудитор, 92 дугаар зүйлд хянан шалгах зөвлөл компанийн үйл ажиллагаанд хяналт тавихаар заасан ч тэдгээрийг сонгох эрхийг ТУЗ, хувь нийлүүлэгчдийн хуралд олгосон нь хараат бус байдлыг алдагдуулж, хяналтыг нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс явуулах боломжгүй болгожээ.

Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын дарга, ҮЦХ-ны дарга, Монгол банкны ерөнхийлөгчийн 1995 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн

Аудитын дүн

хамтарсан тушаалаар “Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдсан компанийн хувьцааг зөвхөн биржээр” арилжих, ҮЦХ-ны “Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа явуулах тухай” журамд “Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасыг биржээс гадуур арилжихыг хориглох”-оор зааж биржийн гадуурхи арилжааг эхнээс нь зөвшөөрөөгүй нь төрөөс хөрөнгийн зах зээлийг зохицуулах, хяналт тавих хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зорилготой байжээ.

Гэвч хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зардал чирэгдэл багатай зарах боломжийг олгох зорилгоор, ҮЦХ-ны 1998 оны 09 дүгээр тогтоолоор “Үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхийг шилжүүлэх тухай журам”-д “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг биржийн арилжааны бус хэлцлээр худалдах” тухай 6 дугаар бүлгийг нэмж оруулсан нь, уг журмын 1 дүгээр зүйлд энэхүү журмын зорилго нь үнэт цаасыг биржийн арилжаагаар худалдах, худалдан авах,...тай холбогдсон арилжааг зохицуулахад оршино гэсэн заалт зөрчигдөхөд хүргэжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлд төрд ногдох хувьцаа, ногдол хувийг ТӨХ-ны шийдвэрээр биржээр болон дуудлагын худалдаа, уралдаант шалгаруулалтын хэлбэрээр биржийн гадуур худалдахаар заасан боловч ямар компанийн хувьцааг биржийн гадуур худалдах талаар тодорхой заагаагүй байна.

ҮЦ33-ийн тухай хуульд үнэт цаасны дахин арилжаа, үнэт цаас эзэмшигч иргэдийн эрх зүйн харьцааг орхиж, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үйл явцыг тодорхой хуульчлаагүй, хуулийн нэр томъёоны хэсэгт үнэт цаасны хоёрдогч зах зээлийн тухай тайлбарласан боловч бусад хэсэгт хоёрдогч зах зээл гэсэн нэр томъёо огт ороогүй байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын хуралдаанаар баталсан компанийн засаглалын зарчмуудад хувьцаа эзэмшигчдийн эрх, хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах, оролцогч талуудын үүрэг, тайлагнах болон ил тод байдал ТУЗ-ийн үүрэг хариуцлага багтаж байна. Гэтэл эдгээр зарчмуудад хамаарах компанийн ашгаас хувь хүртэх, компанийн талаарх мэдээллийг авах, хувьцааг шилжүүлэх боломжоор хангагдсан байх, санхүүгийн мэдээллийг стандартад нийцүүлэн бэлтгэсэн байх, ТУЗ-д хангалттай олон бие даасан хараат бус гишүүдийг томилох зэрэг зарчмууд манай нөхцөлд хангагдахгүй байна.

ҮЦХ нь ҮЦ33-ийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны тухай хууль тогтоомжийн биелэлтэд

Аудитын дүн

хяналт тавих үүрэгтэй ч, ҮЦЗЗ-ийг хөгжүүлэх бодлого боловсруулах үүрэг заагаагүйгээс, санхүүгийн тогтолцоог уялдуулах, хувьцааны төвлөрлийг эдийн засгийн арга болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож зохистой хэмжээнд тогтоох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд төрийн зохицуулалт хийх, ҮЦЗЗ-ийн талаар сурталчилгаа хийх зэрэг бодлогын чанартай ажил орхигджээ.

Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

Хөрөнгийн зах зээл гэдэг нь ХК-уудад ашиглагдаж буй хувьцаа, бонд, Засгийн газраас гаргаж буй бонд зэрэг үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, худалдах, худалдан авах, эдгээр ажиллагааг зуучлах ажиллагааны нийлбэрээс гадна үнэт цаас гаргагчид, түүнийг худалдан авагчид, тэдгээрт зуучлагчид буюу андеррайтер, диллерүүд гэсэн гурвалсан субъектүүдийн хамтарсан ажиллагаа юм. Одоогоор манай улсын хөрөнгийн зах зээлийг хувьцаа, буюу бонд бүрдүүлж, 1995-2004 онд 118.0 тэрбум төгрөгийн хувьцаа, 267.2 тэрбум төгрөгийн бонд арилжаалагджээ.

Хувьцаа

Монгол Улсын Засгийн газраас 1990 онд нийт хөрөнгийн 44.2 хувь буюу 22.0 тэрбум төгрөгийн өмчийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлалд хамруулсан байна.

1997-2004 онд төрийн өмчийн 75.9 тэрбум төгрөгийн хувьцааг ТӨХ хувьчилсан, аж ахуйн нэгжүүд 4.5 тэрбум төгрөгийн нэмэгдэл хувьцаа гаргасан, хөрөнгийн биржээр 33.5 тэрбум төгрөгийн, биржийн бус хэлцлээр 1.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, том хувьцаа эзэмшигчид тендер санал гаргаж 2.7 тэрбум төгрөгийн хувьцаа авснаар хувьцааны төвлөрөл явагдсан байна.

А. Төрийн өмчийн хувьцааг ТӨХ худалдаж хувьчилсан талаар

Өнгөрсөн хугацаанд ТӨХ-оос 205 аж ахуйн нэгжийн төрийн өмчийн хувьцааг худалдсанаас 12 аж ахуйн нэгжийн 1,8 тэрбум төгрөгийн хувьцааг биржээр худалдсан ба үүний 1,2 тэрбум төгрөг нь УИД-ийн хувьцаа байна. Төрийн өмчийн хувьцааг биржийн арилжаагаар оруулаагүйгээс хувьцаа нийтэд чөлөөтэй арилжигдаж байх хуулийн заалт зөрчигдөж өмч хувьчлалын үйл явцад сөргөөр нөлөөлжээ.

Биржийн хувьцааны ханш бодитой бусаас худалдах доод үнэ бодитой бус тогтоогдож байжээ. Жишээ нь:

Компанийн нэр	Хувьчлагдах хөрөнгө (сая. төг)	ЗГ-ын 160,84 тогтоолоор худалдах доод үнэ (сая. төг)	Зарагдсан үнэ (сая. төг)
УБ БУК	1149.1	28.7	250.6
УБ барилга ХК	350.1	8.2	169.8

Аудитын дүн

Энэ үнэ хэт багаас УБ БУК-д сүүлийн 3 жилийн татварын өмнөх ашгийн дунджаар, УБ барилга ХК-д жилийн эцсийн бараа материалын үлдэгдэл дээр үндсэн хөрөнгийн элэгдлийг нэмснээр, түүнчлэн Сэлэнгэ аймгийн ГТҮ-ийн хувьчлалд Алтан тариа, Дарханы ГТҮ-ийн хувьчлагдах үеийн нэгж хувьцааны ханшийг нэмж дундажлах гэх мэтээр тухайн үед үйлчилж байсан эрхийн актад заагаагүй аргаар худалдах доод үнийг тогтоож байжээ.

Б.Иргэд үнэт цаасыг биржээс гадуур өөр хоорондоо арилжсан талаар

ҮЦХ-ноос биржийн бус арилжааг зөвшөөрснөөр 1998-2004 онд 1.5 тэрбум төгрөгийн 10.3 сая ширхэг хувьцаа биржээс гадуур зарагджээ. Зарим ХК-ийн хувьцааны нилээд хувь тухайлбал, Ингэт толгой ХК-ийн 43%, Ханын материал ХК-ийн 26%, Баяндулаан ХК-ийн 76% нь биржийн бус хэлцлээр зарагдсан ба ХААБЗ, Талх чихэр, Асби зэрэг компанид биржийн болон биржийн бус ханш 4-5 дахин зөрүүтэй байжээ..

Нийт арилжааны дүнд биржийн бус арилжаа жилд дунджаар 7 хувь эзэлж байсан ч харицангуй хямд үнээр 1.5 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдаж, хувьцааны ханш буурах, төвлөрөл явагдахад зохих хэмжээгээр нөлөөлж, иргэд үнэт цаасны арилжаанд бүрэн суралцаагүй манай нөхцөлд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зарим талаар хохироход хүргэжээ. Энэ бүх байдлыг харгалзан дээрх заалтыг ҮЦХ-ны 2005 оны 12 дугаар тогтоолоор хүчингүй болгожээ.

В. Аж ахуйн нэгжүүд нэмэгдэл хувьцаа гаргасан талаар

Өнгөрсөн хугацаанд 45 компани нэмэгдэл хувьцаа гаргасан, өөрийн хувь оролцоог үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн Сонсголон бармат, Тахь ко, Монгол нэхмэл ХК-иудын асуудлууд хууль хяналтын байгууллагад шалгагдаж байжээ.

Аудитын явцад нэмэгдэл хувьцаа гаргасан зарим компанийн материалтай танилцахад Сонсголон бармат ХК-д тоног төхөөрөмж суурилуулсан 107,8 сая төгрөгөд тооцон 1.1 сая нэмэлт хувьцаа гарган байгууллага, хүмүүст эзэмшүүлсэн нь хууль зөрчсөн тухай зарим жижиг хувьцаа эзэмшигчдээс гомдол гаргасныг Чингэлтэй дүүргийн болон Нийслэлийн шүүхийн шийдвэрээр хүчингүй болгожээ .

Зарим компани нэмэлт хувьцааг их хэмжээгээр гаргаснаар цөөн тооны хүмүүс хөрөнгийн 40-90 хүртэл хувийг эзэмших эрхтэй болжээ. Тухайлбал, Ээрмэл ХК 1079.3 мянган хувьцаатай байснаа 2400.0 мянга, Нэхээсгүй эдлэл ХК 103.1 мянган хувьцаатай байснаа 1185.4 мянган хувьцаа нэмж гаргасан байна.

Аудитын дүн

Нэмэлт хувьцаа гаргах үед хөрөнгийг дахин үнэлж эрхийн бичгээр авсан хувьцаатай харьцуулан тооцоогүй, өндөр үнэтэй хөрөнгө байгууллагадаа орлого болгох алдагдал болон зээлийг төлсөн гэсэн үндэслэлээр нэмэлт хувьцаа гаргах байдал ХК-иудад гарчээ.

Компанийн тухай хуулийн 39.6 дахь заалт, ҮЦТХ-д Компани үнэт цаасыг нийтэд, эсхүл нийтэд санал болгохгүйгээр цөөн тооны этгээдэд худалдахаар гаргана гэсэн заалтыг баримтлан нэмэлт хувьцаа гаргасан ихэнх компаниудын том хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлага болох давуу мэдээлэлтэй хувьцаа эзэмшигчид хувь нийлүүлэгчдийн болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг өөрт ашигтай байдлаар гаргуулж байсны дээр компанийн хуулийн 56.2-т заасны дагуу хувьцааны үнээ ч өөрсдөө тогтоож байжээ.

Ийм нөхцөлд ҮЦТХ-ийн 20 дугаар зүйлийн 6-д заасны дагуу нэмэлт хувьцаа гаргах явцад гарч буй зөрчлийг таслан зогсоох хяналтыг ҮЦХ-ноос тухай бүр хийгээгүй байна.

Г. Тендер санал гаргаж хувьцаа худалдан авсан талаар

Үнэт цаасны зах зээлд 2003 он хүртэл хугацаанд 28 ХК 2.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий 7.4 сая ширхэг хувьцааг худалдан авахаар тендер санал гаргажээ. Тендер санал гаргаж авсан компанийн биржийн ханш, хувьцааны зах зээлийн ханшийг бодитой илэрхийлж чадахгүй байна. Тухайлбал:

Компанийн нэр	Тендер саналаар авсан үнэ (төг)	Хөрөнгийг 3 3 үнээр дахин үнэлсэн балансаар тооцсон үнэ (төг)	Тендер саналаар авсан тоо ширхэг
Дорнод ХК	100	1390	421800
Дарзам ХК	100	28872	75981
Сонсголон бармат ХК	100	26580	415528
Дархан мах экспо ХК	100	3480	168540

Зах зээлийн үнийг бүрэн харуулж чадаагүй биржийн ханшийг харгалзан, уг хувьцааг авах сонирхолтой тал тендер санал гаргах үнийг тогтоож байгаа нь Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлтэй зөрчилдөж, бодит үнэ нь өндөр байгаа хөрөнгийг мэдээлэл сайтай цөөн эзэмшигчид хямд үнээр авах боломж олгож байна.

Манайд гол хувьцаа эзэмшигчид ихэнхдээ ТУЗ-д байдаг, хараат бус байхаар орсон гишүүн нь хараат бус байх бололцоогүй, хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ бараг хийлгэдэггүй зэргээс Компанийн тухай хуулийн 56-ийн 2, 3, 4 дүгээр заалтууд хэрэгжихгүй байна.

Бонд А.Засгийн газрын бонд

Аудитын дүн

Монгол Улсад 1991 онд Засгийн газраас бонд гаргаснаар бондын зах зээлийн эхлэл тавигдсан байна. 1996 онд хямдруулсан бонд, 2000 оноос богино болон дунд хугацааны хямдруулсан бондыг биет бусаар гаргаж нийт 124.9 тэрбум төгрөгийн бондыг биржээр, 154.2 тэрбум төгрөгийн бондыг төрийн сангаар дамжуулан арилжаалжээ.

Бондын арилжааг он оноор харуулбал; Тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	1991	1996	2000	2001	2002	2003	2004	2005	ДҮН
Нийт арилжигдсан бонд	0.3	0.1	18.9	39.7	49.9	111.9	41.6	16.7	279.1
Үүнээс: ХБ-ээр арилжигдсан бонд	0.2	0.1	11.1	30.8	41.7	21.7	12.5	6.8	124.9
Эзлэх хувь	66.7	100	57.8	77.6	85.6	19.4	30.0	40.7	44.75

Засгийн газрын хямдруулсан бондыг 60-150 хоногийн хугацаатай гаргасан ба хугацаанаас хамаарч хүү харилцан адилгүй байжээ. Бондын хүү 2000 онд өндөр байснаа огцом буурч байгаад 2004 онд эргээд өссөн боловч 2000 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

2004 онд хямдруулсан бондын сарын дундаж хүү хадгаламжийн сарын дундаж хүүгээс 53.3 хувиар, зээлийн хүүгээс 62.9 хувиар бага байжээ.

2004 онд Эрдэнэт УҮГ-аас орлогын албан татварт төлсөн 6.5 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлого болголгүй, Сангийн сайдын 2004 оны 277 дугаар тушаалаар энэ хэмжээний нэрлэсэн үнэтэй, 3 хоногийн хугацаатай, хүүгүй бонд гаргаж арилжсанаар дансны бичилт хийж бондын өглөг болгон харуулжээ.

Б.Компанийн бонд

2001-2005 онд Хөрөнгийн бирж дээр орон сууцны барилга, аймаг сумдын холбооны нэгдсэн сүлжээ бий болгох төсөл, жижиг дунд бизнесийг дэмжихэд зориулан олгох зээлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор 8 компани бонд гарган арилжаалсан байна. Үүнээс 2001 онд 1.2 тэрбум, 2002-2004 онд 2.7-2.9 тэрбум төгрөгийн бонд арилжигджээ.

Өнгөрсөн онуудад компанийн бондын нэрлэсэн үнэ 5-120 мянган төгрөгт, сарын дундаж хүү 1.6-1.8 хувь буюу банкны хадгаламжийн сарын хүүгээс өндөр, зээлийн хүүгээс доогуур байжээ.

Аудитын дүн

Компанийн бонд гаргалт болон бүртгэлээс хасагдсан байдал:
(2001-2005 он)

1		Бонд гаргалт		Хасагдсан Бонд /мян.шир /	Зарагдсан /2005 он хүртэл сая.төг/
		Мян/ ш	Сая/төг		
1	Шинэ зуун	537.7		417.7	
2	Нийслэл өргөө	520.0	2600.0		1086.5
3	Пума	100.0	1000.0		168.1
4	MCS электроникс	34.7	2400.0	14.7	1500.0
5	Анод	200.0	2000.0		17.9
6	Их барилга	100.0	1000.0	0.3	996.9
7	Их барилга төсөл	56.0	2800.0	16.0	1300.0
8	Говь	100.0			
	Дүн	1648.4		448.4	5069.4

Бондын зах зээлийг хөгжүүлэхэд бондын барьцаа баталгааны төрлийг нэмэгдүүлэх, андеррайтер, хөрөнгө оруулалтын банк байгуулахыг дэмжих, тэтгэврийн болон даатгалын сангуудын хөрөнгийг үнэт цаасны зах зээлд татан оролцуулах, бондын орлогоор санхүүжих ажлын үр дүн, гүйцэтгэлд хяналт тавьж хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй ажиллах нь чухал юм.

Хөрөнгийн зах зээлд тулгарч буй асуудлууд

2004 оны 11 дүгээр сарын эцсээр мөнгөний нийлүүлэлт 839.5 тэрбум төгрөгт хүрч урьд оноос 19.3 хувиар өссөн, хувийн секторт олгосон зээлийн хэмжээ 2003 оны эцсээс 172.4 тэрбум төгрөг буюу 51.3 хувиар өссөн, банкуудын хадгаламжийн хүүгийн түвшин буурсан нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд таатай нөхцөл бүрдүүлсэн байна.

Хөрөнгийн зах зээл нь төрийн мөнгөний бодлого түүний бүрэлдэхүүн хэсэг болох банк хоорондын зах, валютын арилжаатай нягт уялдаатай байдаг. Гэвч манайд санхүүгийн урт хугацаатай эх үүсвэрийг байршуулах, худалдах, худалдан авах талаар хөрөнгийн зах зээл болоод банкны салбарын хооронд өрсөлдөөн үүсэх бололцоогүй байна.

2003 онд нийт бүртгэгдсэн компанийн 26 хувь нь хувь нийлүүлэгчдийн хурлаа хийж, хурлын материал, шийдвэрээ, 32 хувь нь хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлангаа ҮЦХ, ХБ-д ирүүлж, 20 хувь нь хураангуйг хэвлэлд нийтлүүлжээ. Хувьцааны төвлөрөл болж 1.3 мянга гаруй гол хувьцаа эзэмшигчдийн нилээд нь гэр бүл, ах дүүс байдгаас хувь нийлүүлэгчдийн хурлын агуулга алдагдаж, хурлын материал шийдвэрийг ҮЦХ, ХБ авах, түүнд дүгнэлт хийх нь ач холбогдол багатай байна.

Анх хувьцааны нэрлэсэн үнийг 100 төгрөгөөр тогтоож хувьчлал явагдсан

Аудитын дүн

бол одоо түүнд ногдох хөрөнгийн үнэ олон дахин өссөн байхад компанийн хуулийн боловсронгуй бус, хувьцаа эзэмшигчид хяналт тавих нөхцөл бүрдээгүйгээс шалтгаалан 1.3 мянга гаруй том хувьцаа эзэмшигчид, 400.0 гаруй мянган жижиг хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг ногдол ашгийг өгөхгүй, үнэгүй ашиглах бололцоо олгож байгаагийн дээр хувьцаа эзэмшигчдийн 1.0 тэрбум гаруй төгрөгийг дампуурах шахсан банкинд байршуулан алдаж, үүнээс 653.3 сая төгрөг төлөгдөөгүй нь иргэдийн хөрөнгийн зах зээлд итгэх итгэлд сөргөөр нөлөөлжээ. Дээрх алдагдлыг төрийн өмчийн нэр бүхий аж ахуйн нэгжийн хувьчлалын орлогоос төлөхөөр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэснээс Бэрх-Уул ХК-ийн хувьчлалын орлогоос орсон 93.4 сая төгрөгийг зарцуулах эрхийг Сангийн яамнаас Хөрөнгийн биржид олгоогүй байна. Ногдол ашиг тараасан байдлыг харуулбал;

Он	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Ногдол ашиг тараасан компанийн тоо	110	85	69	49	55	23	18	24	14	19	13

Хүснэгтээс үзвэл 1993 онд нийт ХК-ний дөнгөж 20 хүрэхгүй хувь ногдол ашиг тарааж байсан бол энэ үзүүлэлт жил бүр буурч 2002 гэхэд 4 хувь болжээ. 1993 онд нэгж хувьцааны ногдол ашигт 4 компани 100-аас дээш төгрөг, 102 компани 1 төгрөг 26 мөнгөнөөс 50 төгрөг хуваарилсан бол мөнгөний ханш буурч сарын дундаж цалин 1993 онд 3,6 мянган төгрөг байсан бол 2002 онд 36,2 мянган төгрөг болоод байхад 2003 онд 13 компани 3-300 төгрөг хуваарилсан нь компаниас ногдол ашиг хүртэх зарчим алдагдсаныг харуулж байна. Том хувьцаа эзэмшигчид компанидаа ажиллаж эрх мэдэл, хангамж эдэлж байгаа учир ногдол ашиг олгоогүйгээс хохирол амсахгүй байна.

Иймд олон жил ногдол ашиг хуваарилаагүй компанид хүлээлгэх хариуцлагыг бий болгож, хувьцаагаа зах зээлийн бодит үнээр эргүүлж авахыг шаардах эрхтэй болгох, улмаар дампууруулах замаар өөрт ногдох хөрөнгөө авах боломжийг олгох нь зүйтэй юм.

2003 оны жилийн эцсийн байдлаар 314 компанийн хувьцааны арилжааны ханш нэрлэсэн үнэ 100 төгрөгөөс доогуур байна. Хөрөнгийн биржийн ханш хувьцааны бодит ханшийг илэрхийлж чадахгүй байгааг дараахь хүснэгт харуулж байна.

Компанийн нэр	2004 СТ-аар нэгж хувьцааны балансын үнэ	төгрөгөөр
		2005 оны эхний хагас жил биржийн ханш
Хүрд ХК	7890	50
Монгол ЭЭГ ХК	6836	21
Монинжбар ХК	5497	5

ҮЦХ-ноос 2003 онд нийт 410 ХК-д хийсэн үзлэгээр хувьцааны

Аудитын дүн

төвлөрөл 90 орчим компанид 75 хувиас, 97 компанид 90 хувиас дээш байгаа нь далд утгаараа ихэнх нь ХХК болсныг харуулж байна. Ингэж хувьцааны төвлөрөл явагдсаны дүнд Монголд анх 1.3 сая шахам хувьцаа эзэмшигч байсан бол одоо 1.3 мянга гаруй хүнд бүх хувьцааны 73.5 хувь төвлөрсөн нь хөрөнгийн биржийн үйл арилжаа багасах нэг шалтгаан болжээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 25,4 хувь нь 1-10 хувьцаатай, 12,5 хувь нь 1-3 хувьцаатай, тэдгээр нь нийт хувьцааны 0.8 хувь болж байна.

Хувьцааны төвлөрөл болсон компанийн ихэнх нь алдагдалтай ажиллаж, ногдол ашиг хуваарилдаггүй, орлогын албан татвар төлдөггүй нь, хувьцааны төвлөрлийн зохистой хэмжээг тогтоох зорилгоор хөрөнгийн татварыг хувьцаанд ногдуулах гэх мэт эдийн засгийн аргаар нөлөөлөх шаардлагатай байсныг харуулж байна.

Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд өөрчлөн байгуулагдах нөхцөлд хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрх үүсэхээр зааснаас 2004 онд 30 мөнгөний ногдол ашиг хуваарилсанаас өөр ногдол ашиг өгч байгаагүй УИД ХК “хяналтын багцыг хувьчлалын дүнд авсан тул худалдан авах үүрэг хүлээхгүй” гэж ҮЦХ-д мэдэгдэн 12.2 сая ширхэг хувьцаа эзэмшиж буй 57 мянган иргэний эрх ашгийг хохироож байна.

Хувьцааны төвлөрөл явагдах үед гарсан хууль бус үйлдлүүдэд аудиторунд болон хянан шалгах зөвлөл компанийн удирдлагад шүүмжлэлтэй хандсан дүгнэлт гаргаж байгаагүй нь Компанийн тухай хуулийн 91, 92 дугаар хуулийн заалт амьдралд хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Өнгөрсөн хугацаанд нийлэх хэлбэрээр 1, нэгдэх хэлбэрээр 10, ХХК-д шилжих хэлбэрээр 44 компани өөрчлөн зохион байгуулагдаж, 4 компани татан буугдсан байна. ҮЦХ-ны шийдвэрээр 60 компани өөрчлөн байгуулагдсаны 21 нь нэгж хувьцааны үнийг 9-100 төгрөгөөр тооцон, хувь нийлүүлэгчидтэй тооцоог бүрэн хийлгүй 184.5 сая төгрөгийн ногдол хувийг МХБ-д шилжүүлсэн нь тэднийг хохирооход хүргэж болохыг анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал, Цемент ХК 1998 онд төрийн мэдлийн 181.2 мянган хувьцааг нэг бүрийг нь 402 төгрөгөөр худалдан авсан атал түүнээс 5 сарын дараа жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол хувьд 208.3 мянган хувьцааг нэг бүрийг нь 77 төгрөг 33 мөнгөөр бодож Хөрөнгийн биржид шилжүүлжээ.

Компанийн ашиг нэмэгдэх, улмаар зах зээл дэх үнэт цаасны үнэ өсөхөд хувьцааныхаа үнийг бууруулах, хөрөнгө оруулагчдын хүрээг нэмэгдүүлэх зорилгоор хувьцааг задалдаг. Гэтэл компанийн тухай хуулийн 44.1.3-д компани үүсгэн байгуулах үед хувьцааны үнийг тогтоосон бол дахин тогтоож болохгүй гэж заасан нь дээрх зарчимтай

Аудитын дүн

зөрчилдөж, 22 дугаар бааз өөрийн хувьцааг задлан нэгж хувьцааны үнийг 10 төгрөгөөр тогтоосон нь хууль зөрчсөн үйлдэл болгоход хүргэжээ.

Хөрөнгийн бирж, ҮЦТТТХТ-ийн үйл ажиллагаа

Үнэт цаасны арилжааны зохицуулалт

Үнэт цаасны арилжааг Монголын хөрөнгийн бирж ХК-ийн арилжаа судалгааны алба зохих журмыг мөрдөн явуулж байгаагаас 1995-2005 оны эхний хагас жилд 40.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 216.3 сая ширхэг хувьцаа арилжаалагджээ.

2004 онд өмнөх жилээс хувьцааны арилжааг 20-30 хувь буурахаар, Засгийн газрын бондын арилжааг хэвийн хэмжээнд байлгахар, компанийн бондын арилжааг 20 хувиар өсгөхөөр зорилт тавьсан ч бондын хувьд төлөвлөсөн хэмжээнд хүрч чадаагүй байна.

2004 онд хөрөнгийн биржээр 9.1 сая ширхэг хувьцаа, 130.0 мянган ширхэг Засгийн газрын бонд, 69.2 мянган ширхэг компанийн бонд арилжигдаж, нийт 15.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэнийг өмнөх онтой харьцуулбал;

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2003 он	2004 он	Үнийн дүнгээр	Хувиар
Хувьцаа	895.9	654.0	- 241.9	- 27.0
ЗГ-ын бонд	21,722.5	12,463.8	- 9,258.7	- 42.6
Компанийн бонд	2,988.3	2,776.5	- 211.8	- 7.1
Дүн	25606.7	15894.3	9712.4	-37.9

2004 онд хийгдсэн хувьцааны арилжаа нь өнгөрсөн оноос тоо ширхгийн хувьд 979.9 мянган ширхэг буюу 12.1 хувиар өссөн ч үнийн дүнгийн хувьд 241.9 сая төгрөгөөр ба 27 хувиар буурчээ. Харин 2005 оны эхний хагас жилийн байдлаар 1.5 тэрбум гаруй төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс арилжааны үнийн дүнгийн хувьд 5.1 дахин өссөн, энэ нь дундаж ханш бага зэрэг өссөн, биржийн бус арилжааг зогсоосон зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын бондын арилжаа 3 удаа явагдаж 130.0 мянган ширхэг бондыг 12.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь өмнөх оноос 42 хувиар буурсан байна. 2004 онд судалгааны албанаас бондын арилжааг өргөжүүлэх талаар судалгаа явуулж, бондоор санхүүжих боломжийн талаар 16 аж ахуйн нэгжид зөвлөгөө өгснөөр 2004 онд 3 компани бонд гаргаж 1.5 тэрбум төгрөгийн, 2005 онд Говь ХК бонд гаргаж 506.0 сая төгрөгийн санхүүжилт олжээ.

2004 онд бонд гаргагч компанийн тоо нэмэгдсэн ч зах зээлд

Аудитын дүн

2776.5 сая төгрөгийн үнэ бүхий 69.2 мянган ширхэг компанийн бонд арилжигдсан нь өнгөрсөн оноос үнийн дүнгийн хувьд 211.8 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар, тоо ширхэгийн хувьд 178.2 мянган ширхэгээр буюу 144.6 хувиар тус тус буурчээ.

Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа

ҮЦЗЗ-ийн тухай хуулийн дагуу үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааг гүйцэтгэх үүрэгтэй төрийн өмчит ҮЦТТХТ ХХК-ийг 2003 онд Хөрөнгийн биржээс тусгаарлан байгуулжээ.

Тус компанид 2005 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 377.6 мянган харилцагчдын 401 нэр төрлийн 2.1 сая ширхэг үнэт цаас, 542.2 сая төгрөг хадгалагдаж, хувьцаа, бонд болон ногдол ашиг, ногдол хувийн нийт 1656.3 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна. Үүний 39.4 хувь буюу 653.3 сая төгрөг банк дампуурснаас эрсдэлд орсон 227.5 мянган харилцагчид өгөх өглөг байгаагаас 77.6 мянган харилцагчид өгөх 350.4 сая төгрөгийн хувьцааны өглөг, 149.9 мянган харилцагчид өгөх 303.1 сая төгрөгийн ногдол ашгийн болон ногдол хувийн өглөг байна.

Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар 2000 оны 10 сарын 1-ээс хойш орсон мөнгийг бодит, түүнээс өмнөхийг бодит бус гэж ангилснаар дээрх хугацаанаас хойш мөнгө тушаасан болон тэдэнд хувьцаагаа худалдсан харилцагчдын мөнгө нэг өдөртөө олгогдож иржээ.

ҮЦТТХТ ХХК-иар ногдол ашиг тараалгах компанийн тоо цөөрсөөр байгааг дараахь хүснэгтээс харж болно.

Үзүүлэлт	2000 он	2001 он	2002 он	2003 он	2004 он
НА тараасан компани	24	14	19	13	11
Тараасан НА сая төг	1800.0	1200.0	1100.0	512.3	896.2
Бирж ба ТТХТөвөөр	3	2	4	5	2

2004 онд 2003 оны ажлын үр дүнгээр 11 компани 896,2 сая төгрөгийн ногдол ашиг тарааснаас 8.5 хувь буюу 76.4 сая төгрөгийг Атар өргөө, Спирт бал бурам ХК-иуд ҮЦТТХТ ХХК-иар, бусад нь компани дээрээ тараажээ. Ихэнх тохиолдолд авах ногдол ашиг нь гарах зардлаасаа бага байдгаас (2004 онд нэгж хувьцаанд 3-300 төгрөг) хувьцаа эзэмшигчид очиж авахгүй компанидаа үлдэж байгаа нь өөрөө тараах сонирхлыг төрүүлж байна. ҮЦТТХТ ХХК-ийн 2005 оны эхний хагас жилийн балансаар давхардсан тоогоор 1233.1 мянган харилцагчид олгох 420.9 сая төгрөгийн ногдол ашгийн болон ногдол хувийн өглөгтэй гарсан нь үүнийг нотлож байна

БДК-иуд харилцагчдын хувьцааг зөвшөөрөлгүй зарж үнийг нь

Аудитын дүн

завшсан тохиолдол илэрч, 13 иргэний хохирлыг барагдуулснаас үзвэл харилцагчийн буцаан татаж буй бэлэн мөнгө ҮЦТТТХТ ХХК болон БДК-иудаар дамжиж байгаа нь харилцагчдын мөнгийг завших боломжийг бүрдүүлж болзошгүй байгаагаас цахим картаар хийх шаардлагатай байна.

Дотоод хяналтын тогтолцоо, үр нөлөө

МХБ ХК-д Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан “Хөрөнгийн бирж ХК-ийн хяналтын журам”-ын дагуу БХА дотоод хяналтыг гүйцэтгэж, ҮЦТТТХТ ХХК-д 2005 оны 5 сараас дотоод хяналтын ажилтан ажиллаж байна.

МХБ ХК-ийн БХА нь дотоод хяналтыг гүйцэтгэхдээ үнэт цаасны үнэ ханшийн өөрчлөлт, тодорхой түвшинд зохиомлоор барих, өсгөх бууруулах үйлдэл, хуурамч болон давхар гүйлгээ хийх ажиллагаа байгаа эсэх болон арилжааны дэг, БДК-иудын үйл ажиллагаа зэрэгт хяналт тавих үүрэгтэй юм. ҮЦТТТХТ ХХК-ийн дотоод хяналтын ажилтан төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа болон мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хяналт тавих үүрэгтэй ажээ.

Хөрөнгийн биржийн БХА нь гүйцэтгэх захирлын баталсан төлөвлөгөөний дагуу өдөр тутмын арилжааны явцыг програмын тусламжтай хянахын зэрэгцээ арилжаа хөтлөгчөөс арилжааг хийсвэр үнийн түвшинд хийгдлээ гэж үзэж, хянуулахаар хүсэлт ирүүлбэл түүнийг тухай бүрд нь шийдвэрлэх ” МХБ-ийн гишүүний үйл ажиллагааны тухай журам”, “БДК-иудын ажилчдын ёс зүйн дүрэм” болон “Харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэх журам”-ыг хэрхэн дагаж мөрдөж байгаад нь БДК-иудад хяналт тавьж байна.

Өнгөрсөн онд БДК-иудад явуулсан шалгалтаар гишүүний үүргээ хангалтгүй биелүүлсэн 16 компанийн арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлж, зөрчлийг арилгасны дараа эрхийг нь сэргээх арга хэмжээ авсан байна.

Тухайлбал, Аргай бэст БДК –ийн ажилтан Л.Гантуяа хувьцааг зөвшөөрөлгүй зарж, хэлцлийг нөхөн бүрдүүлсэн нь дотоод хяналтаар илэрч байсан бөгөөд 2000 онд Эрдэнэст БДК-д ажиллаж байхдаа харилцагчийн 8.4 сая төгрөгийг эзний зөвшөөрөлгүй шилжүүлснээс ТХШХ-ны шалгалтаар акт тавиулж байжээ.

МХБ ХК –ийн БХА-ны ажилтнууд нь гүйцэтгэх захирлын баталсан Хяналтын журмын дагуу биржийн байцаагч гэдэг албан тушаалтай ч хууль зүйн хувьд улсын байцаагчийн эрх авсан хүнгүй байна.

Аудитын дүн

Програм хангамж, мэдээллийн аюулгүй байдал

Монголын хөрөнгийн бирж ХК-д дотоод сүлжээ, интернет, сервер, арилжааны програм хангамжийн найдвартай хэвийн ажиллагаа, түүнд захиалгын дагуу хийх нэмэлт өөрчлөлтийг хариуцах, мэдээллийн нууцлалыг хангахын дээр ажилтнуудад шаардагдах програм хангамжийн мэдлэг олгох, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий програм хангамжийн алба ажиллаж байна.

Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн хөдлөл өөрчлөлтийг мэргэжлийн өндөр түвшинд зохиогдсон програм хангамжийн тусламжтай хийх шаардлагын үүднээс 1999 онд Бодь-Интернэйшнл ХХК-ийн зохиосон цогц програм хангамжаар гүйцэтгэж байна.

Дээрх цогц програм хангамжаас дилерийн програм хангамж үнийн болон цаг хугацааны ахлах дарааллаар хэлцлийг биелүүлэх горимтой, арилжаа хөтлөгчийн програм хангамж БДК-иудын хооронд хийгдэж буй арилжаанаас гадна үнэт цаасны дээд, доод болон дундаж ханшийг өдөр, сар, жилээр, түүнчлэн тухайн үнэт цаасны ханшийн өсөлт, бууралт, арилжааны идэвх өсөх үйлдлүүд харагддаг байна. Мөн дилерүүдийн арилжаанд оролцох болон үнэт цаасны арилжих эрхийг хаах, сэргээх, арилжаа эхлүүлэх, хаах, нийлүүлэлт хийх үйлдлүүд хийгддэг байна.

Хяналтын програм хангамжаар арилжааны үед болон арилжааны дараа хяналт тавих үүрэгтэй ч арилжааны үед тухайн компанийн хувьцаа их хэмжээтэй зарагдвал хувийн жинг тодорхойлдоггүй, гараар гаргадаг, ханшийн хэлбэлзлэл, 52 долоо хоногийн дундаж ханш харагддаггүй сул тал байна.

Хяналтын програмд үнэ ханшийн хязгаар тогтоосон функцгүйгээс үнэ зохиомлоор өсөх ба буурахыг мэдэрдэггүй, үүнийг програмдаа өөрчлөлт хийснээр хянуулж болох ч Арилжааны журамд энэ талын заалт алга байна. 2004 онд АМСА-наас үнэт цаасны ханшийн хэлбэлзлийн шалтгааныг тогтоох, түүнд хязгаарлалт хийх боломжийн талаар хийсэн судалгааны үндсэн дээр өнөөгийн нөхцөлд шууд хязгаарлалт хийх нь үнэт цаасны төвлөрөл болсон компаниудын хувьд боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

1995 оноос өнөөг хүртэлх мэдээллийг 130 орчим CD-д архивласан бөгөөд 2001 онд сервер гэмтсэн үеийн мэдээллийг архивлаж чадаагүйгээс цаасан баримтаар архивт байна. Мэдээлэл давхар нууцлалтай, хэрэглэгч өөрийн нууцлалаар өөрт хамаатай мэдээлэлдээ

Аудитын дүн

нэвтэрдэг, нэг сараас дээш хугацааны чөлөөтэй ба ээлжийн амралттай ажилтны сүлжээнд орох эрхийг программ хангамжийн ажилтан түр хаадаг зэргээр мэдээллийн нууцлалыг хамгаалдаг байна.

ҮЦХ-той харьцах шууд сүлжээгүйгээс арилжааны дүнг и-мэйлээр явуулдаг бөгөөд өргөтгөл хийж арилжааг тэндээс хянах боломжтой ч гарах зардлаас шалтгаалан хэрэгжихгүй байна.

Цаашид харилцагчид үнэт цаасны захиалга, арилжааг интернетээр гүйцэтгэж, бэлэн мөнгөний төлбөр тооцоог цахим картаар хийх шаардлагатай байна.

ҮЦТТТХТ ХХК-д ажиллаж байгаа төлбөр тооцооны болон хадгаламжийн, судалгааны програм хангамж ашиглалтад орсноос хойш хэд хэдэн програм хангамжийн ажилтан ажиллаж, тэд зохих өөрчлөлтийг хэд хэдэн удаа хийснээс анх зохиосон газарт хандах боломжгүй болсон байна.

Цогц програм хангамж зарим талаар өнөөгийн шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, гүйлгээний шимтгэлийн зарим хэсгийг ажилтнууд бодож гараас оруулдаг, судалгааны програм үндсэн баазаас мэдээллээ татаж авч, excel-ийн файлд оруулж зохих боловсруулалт хийдэг, санхүүгийн тайлангаархи ногдол ашгийн болон ногдол хувийн өглөг хэдэн харилцагчид хамаарах, ногдол ашиг хэд, ногдол хувь хэд болох, бодит ба бодит бус хэд болох нь шууд гарахгүй, нэмэлт гар ажилбар хийж гарч байна.

Мөн ҮЦТТТХТ ХХК-иас МХБ ХК-д ирүүлсэн 2005 оны 1/73 тоот албан бичгээс үзвэл харилцагчдын мөнгөний үлдэгдэл зөрснийг шалгаж Б.Дандарбаатарын дансанд 1.8 сая төгрөг үндэслэлгүй нэмэгдсэнийг тогтоож залруулжээ. Иймд гараар засвар хийгдэх боломжгүй, найдвартай програм хангамжаар төлбөр тооцоог гүйцэтгэх, нэг дирдлагатай байх боломжийг судлах шаардлагатай байна.

Санхүүгийн бүртгэл, тайлагнал

2004 онд Монголын хөрөнгийн бирж ХК 215.1 сая төгрөгийн орлоготой, 211.4 сая төгрөгийн зардалтай 3.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 97.6 сая төгрөгийн орлоготой, 213.8 сая төгрөгийн зарлагатай, 116.2 сая төгрөгийн алдагдалтай, ҮЦТТХТөв ХХК-нь 2004 онд 76.3 сая төгрөгийн орлоготой, 69.9 зардалтай, 6.4 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

МХБ ХК-ийн орлогын төлөвлөгөө тасрахад бусад орлого 96.7 сая төгрөг, Засгийн газрын бондын шимтгэл 23.1 сая төгрөгөөр тасарсан нь

Аудитын дүн

гол нөлөө үзүүлжээ.

МХБ ХК 2004 оны жилийн эцсийн байдлаар Бүртгэлийн хураамжаар нийт 118.2 сая төгрөгийн авлагатай, үүний 80.6 сая төгрөг нь найдваргүй авлага болохыг, мөн гишүүний хураамжаар 2.1 сая төгрөгийн авлагатайг БХА-аас шалгаж тогтоосон ч балансад тусгаагүй байна.

Хөрөнгийн биржийн 2040.5 сая төгрөгийн үнэтэй барилгыг ТӨХ-ны 2003 оны 598 дугаар тогтоолоор хоёр хувааж МХБ ХК-ийн балансад 1612.5 сая төгрөг, ҮЦТТХТ ХХК-ийн балансад 427.9 сая төгрөгийн барилга тусгажээ. Гэтэл барилгыг төрийн өмчийн байр гэдэг үндэслэлээр ҮЦТТХТ ХХК элэгдэл байгуулдаггүй, харин МХБ ХК 2004 онд 575.5 мянга, 2005 оны эхний хагас жилд 288.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь хуулийн дагуу барилгын элэгдлийг жилд 2.5 хувиар байгуулах хэмжээнд хүрээгүйн дээр ТӨХ-д улирал тутам 310.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг 2005 оны 4 сар хүртэл төлсөн нь барилгын үнэ балансад тусгагдсан байгууллагын хувьд буруу үйлдэл болжээ.

Тус хоёр байгууллага Нягтлан бодох бүртгэлийн зөвшөөрөгдсөн програм хангамжгүй, арилжаа, төлбөр тооцооны програмаар гарсан дүн мэдээг дахин гараар шивж excel-ээр баланс гаргаж байгааг өөрчилж, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны програмаар тооцогдсон мөнгөн хөрөнгийн болон өглөг, авлагын хөдлөл өөрчлөлт бүртгэлийн холбогдох дансад шууд тусгагддаг нягтлан бодох бүртгэлийн зөвшөөрөгдсөн програм хангамж ашиглах шаардлагатай байна.

2004 оны эцэст Монголын хөрөнгийн бирж ХК-ийн эзэмшиж байгаа 78.3 сая төгрөгийн компанийн бондыг НББОУС-ын дагуу богино хугацаат хөрөнгө оруулалт хэлбэрээр тайлагнах ёстой ч “Аж ахуйгаас авах авлага” гэж ангилж бүртгэжээ.

Дүгнэлт

Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал болон Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, гүйцэтгэсэн ажиглалт, дүн шинжилгээнд тулгуурлан дараахь дүгнэлт хийж байна.

1.Хөрөнгийн зах зээл хумигдан, зогсонги байдалд орж, иргэд хөрөнгийн зах зээлд итгэл алдахад хүрсэн байна.Үүнд олон хүчин зүйл нөлөөлсний дотор дараахь байдал багтаж байна.

- Хөрөнгийн зах зээлтэй холбогдсон хууль эрхийн актууд ялангуяа компанийн хууль боловсронгуй бус, өөр хоорондоо зөрчилтэй, компанийн засаглалын зарчмууд бүрэн хэрэгжээгүй, банк, татвар, даатгалын бодлого хөрөнгийн зах зээлтэй уялдаагүй, хувьцаа төвлөрүүлэх явцад хувьцаа эзэмшигчдэд арилжаанд оролцох жигд боломж олгох, хувьцаа нийтэд чөлөөтэй арилжигдаж байх зарчим алдагдсан;
- Биржийн бус арилжаа хийгдсэн, хувьцааны ханш бодитой бус тогтоогдож, ихэнх компани ногдол ашиг хуваарилаагүй, зарим нь хуваарилсан ч өчүүхэн хэмжээтэй ногдол ашиг олгосон;
- ХК-ын үйл ажиллагаанд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналт ор нэр төдий болсон;
- Төрийн өмчийг хувьцаагаар хувьчлах, хувьцааны төвлөрөл явагдах үйл явц дуусч байгаа энэ үед ҮЦХ-ноос хөрөнгийн зах зээлийн хөгжлийн явцыг дүгнэх, ҮЦЗЗ-ийн үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчид болон нийт иргэдэд сурталчлах, тэдний мэдлэгийг өргөжүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого тодорхойлох талаар хангалтгүй ажилласан байна.

2.Хөрөнгийн бирж ХК болон Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн үйл ажиллагаа, тэдгээрт ашиглагдаж байгаа төлбөр тооцоо, хадгаламж, хяналт, судалгааны программ хангамж, харилцагчид дансаа шалгах, бэлэн мөнгө тушаах, авах үйл явц боловсронгуй бус байна.

Холбогдох байгууллагын санал

Үнэт
цаасны
хорооны
санал



МОНГОЛ УЛС ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

2005 оны 10 дугаар
сарын 14-ны өдөр

228
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ

Улаанбаатар-210646
Утас-313592
Факс /976-1/ -329084

Танай 280 тоотод

Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн төлөв байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн урьдчилсан төсөлтэй танилцаад саналаа хүргүүлэв.



ДАРГА



С.ГҮНДЭНБАЛ

000419

Холбогдох байгууллагын санал

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС
ХӨРӨНГИЙН БИРЖ, ҮЦТТХТ-ийн ҮЙЛ АЖИЛЛАГАА
БОЛОН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

Танайхаас 2005.10.18-эд 280 тоот бичгээр ирүүлсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь саналыг хүргүүлэв. Үүнд:

1.ҮЦЗЗ-ийн тухай хууль, бусад эрхийн актын уялдаа холбоо хэрэгжилт гэсэн хэсэгт:

Тайлбар
1.1-ийг
үзнэ үү

–“ҮЦЗЗ-ийн тухай” хуулийн 18,19 дүгээр зүйлийг дурьдаад төрийн өмчийн хувьцаа, үнэт цаасыг худалдах буюу үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаанд ТӨХ оролцож ирсэн нь хуулийн дээрх заалтуудтай зөрчилдөж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ нь төр нэг талаас хөрөнгө оруулагч, нөгөө талаар хувьцаа эзэмшигч тул үнэт цаасны зах зээлд оролцох эрх нь хуулиар олгогдсон тул оролцож ирсэн нь хууль зөрчжээ гэж үзэж болохгүй.

Тайлбар
1.2-ыг үзнэ
үү

–“Компанийн тухай” хуулийн 39.6-г дурьдаж жижиг хувьцаа эзэмшигчид нэмж гаргаж буй хувьцаанаас авах эрхгүйгээр хуульчлагджээ” гэжээ.

Ер нь 39.6-д заасан шийдвэрийг компанийн эрх барих дээд байгууллага болох хувь нийлүүлэгчдийн хурал гаргаж болох тул/зарим нөхцөлд дийлэнх олонхийн саналаар/ дээрх дүгнэлт хиймээргүй байна.

–“Компанийн тухай” хуулийн 91-р зүйлийг дурьдаж хараат бус байдлыг алдагдуулж, хяналтыг нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс явуулах боломжгүй болгожээ” гэжээ.

Тайлбар
1.3-ыг үзнэ
үү

Нэгэнт хуульд/91.1-91.7.5/ ямар этгээдийг аудитораар сонгон ажиллахыг хориглох, Аудитор юу хийх талаар тодорхой заалтууд байгаа, мөн ХШЗ-ийн тухайд/92.1-92.6/ гишүүдийн тоо, сонгох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх үүргийг компанийн дүрмээр тогтоохыг хуульчилсан, бүрэн эрх, ямар этгээдийг сонгож болохгүй зэргийг тодорхой тусгасан тул тэдгээрийг сонгох эрхийг компанийн ТУЗ болон ХНХ-д олгож болохгүй гэсэн дүгнэлт хийж болохгүй. Харин гаднаас аль нэгэн субъект аудитор болон ХШЗ-ийг сонгоно гэвэл, Компанийн хууль болон дүрмээр зохицуулагдаж буй үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож харин ч хараат бус байдлыг нь алдагдуулахад хүрнэ.

Тайлбар
1.4-ийг
үзнэ үү

–Тайлангийн төслийн 5-р хуудсанд компанийн хувьцааг биржийн гадуур Хорооноос тогтоосон журмаар худалдсан болон “ТӨХ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56-р зүйлд заасны биржээс гадуур компанийн хувьцааг худалдаж байгаа талаар дурджээ.

Холбогдох байгууллагын санал

2

Ер нь Хорооноос гаргасан "Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг биржийн арилжааны бус хэлцлээр худалдах тухай журмын дагуу явагдсан арилжаа нь хувьцаагаа өмчлөх, захиран зарцуулах эрх нь хуулиар олгогдсон иргэд хувьцаагаа өөр хоорондоо мэргэжлийн байгууллагаас зохих мэдээллийг авснаар арилжиж энэ талаархи хэлцлээ албан ёсоор нотариатаар батлуулан Хөрөнгийн биржид бүртгүүлэн зохих шимтгэлийг нь төлж, ТТХ-д өмчлөх эрхээ баталгаажуулж байсан тул биржийн оролцоогүй гадуур хийгдсэн арилжаа гэж үзэх үндэслэлгүй юм. Иймд энэ нь арилжааны бус хэлцлийг биржээр гүйцэтгэж буй хэлбэр юм.

Тайлбар
1.5-ыг үзнэ
ҮҮ

-Иргэдийн өмчлөх эрхийг эдийн засгийн арга болон хуулиар хязгаарлаж болохгүй тул энэ талаар хийх төрийн зохицуулалт орхигджээ/6-р хуудас/ гэсэн дүгнэлт шууд хийх нь аль хэр нийцтэй вэ? Гэдгийг бодож үзэх. Ер нь УИХ-аас жил бүр баталдаг Үндсэн чиглэл болон үе үеийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Хорооны саналаар үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал нэлээд цогц байдлаар тусгагдаж хийгдэж, хэрэгжиж ирсэн ба 2000-2004 онд Засгийн газраас баталсан хөтөлбөрийн дагуу явагдаж ирсэн.

2.Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал гэсэн хэсэгт:

Тайлбар
1.6-г үзнэ
ҮҮ

-Зарим компани нэмэлт хувьцаа, хэтэрхий их гаргасан, нэмэлт хувьцаа гаргах үед хөрөнгийг дахин үнэлээгүй гэсэн дүгнэлт нь тухайн үед энэхүү ажиллагааг зохицуулж байсан хууль эрхийн актаар хориглогдоогүй байсан асуудлыг хөнджээ. Нэмж хувьцаа гаргасан нийт 32 ХК-ийн 28 нь 1999 онд батлагдсан Компанийн тухай хууль, 2002 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль мөрдөгдөж эхэлснээс өмнө нэмж хувьцаа гаргасан билээ. Эдгээр хуулиуд батлагдсанаас хойш 3 ХК нэмж хувьцаа гаргасан. Эдгээрийн хувьцааны үнэ нь 236-8200 төгрөг байсан бөгөөд энэ үнийг хуульд заасан журмын дагуу тогтоосон болно.

Тайлбар
1.7-г үзнэ
ҮҮ

-“Алмааз” ХК-ийн нэгж хувьцаанд оногдох хөрөнгийг 18 төгрөг 53 мөнгөөр бодож Хөрөнгийн биржид шилжүүлжээ”/12-р хуудас/ гэсэн нь ташаа дүгнэлт байна.

“Алмааз” ХК нь одоо хүртэл Хороо, Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани хэвээр байгаа юм. Дээр дурдсан 18 төгрөг 53 мөнгө нь ногдол ашгийн мөнгө юм.

-Компанийн тухай хуулийн 44.3-д “компани үүсгэн байгуулах үед хувьцааны үнийг тогтоосон” бол дахин тогтоож болохгүй гэсэн заалт нь мөн хуулийн 52 дугаар зүйлд заасан хувьцааг хуваах тохиолдолд хамаарахгүй юм./13-р хуудас/.

Тайлбар
1.8-ыг үзнэ
ҮҮ

Учир нь хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй нэг ширхэг хувьцаа нь 10 ширхэг болон хуваагдсан тэдний эзэмшиж буй хувьцааны тоо 10 дахин өссөн юм. Иймд нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 10 дахин бууруулсан нь хууль ч зөрчөөгүй, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ч хохироогүй үйл ажиллагаа

Холбогдох байгууллагын санал

3

болно. Компани санхүүгийн бодлогоор хувьцаагаа хувааж үнийг бууруулах, нэгтгэн үнийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулийн дагуу хийгдэж буй ажиллагаа. Үүнийг хориглох нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хязгаарлах, зах зээлийн зарчим, мөрдөгдөж буй журам, дүрмийг зөрчих үйл ажиллагаа болох юм.

Тайлбар
1.9-ийг
үзнэ үү

-Аудитын тайланд "Аудитын явцад нэмэгдэл хувьцаа гаргасан зарим компанийн материалтай танилцахад "Тахь-Ко" компанийн ТУЗ-ийн дарга Р.Лутаа компанийн 68,7 сая төгрөгийн зээлийн өр, барилгын засварын 89,9 сая төгрөгийг хувиасаа төлсний үнэнд нэмж гаргасан мөнгө банкинд ороогүй байна" гэжээ. Энэ нь буруу ташаа дүгнэлт болсон байна. Учир нь 1996 онд "Тахь-Ко" ХК-иас нэмж гаргасан 687610 ширхэг хувьцааг Р.Лутаа эзэмшсэн, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн дагуу/ түүний төлбөрийг хийсэнтэй холбогдох асуудлыг иргэн С.Дамдиндоо нарын өргөдөл, нэхэмжлэлийн дагуу Чингэлтэй дүүргийн болон Нийслэлийн шүүх, Улсын дээд шүүх тус тус хянан хэлэлцээд Р.Лутаа нь хувьцааны төлбөрийг хийсэн болохыг нотолж шийдвэр гаргасан билээ.

Мөн энэ асуудлыг Мөрдөн байцаах газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалган, 687610 ширхэг хувьцааны төлбөрийг Р.Лутаа хийсэн болохыг баримтаар нотолж, Нийслэлийн прокурорын газрын Хяналтын прокурор Б.Өнөрмаагийн 2005 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Р.Лутаа нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон болохыг анхаарна уу.

Тайлбар
1.10-ыг
үзнэ үү

3.Хөрөнгийн зах зээлд тулгарч буй асуудлуудын тухайд:

-“Хувьцаа төвлөрч, гэр бүл, ах дүүс болсноос хувь нийлүүлэгчдийн хурлын ач холбогдол алдагдаж, үнэт цаасны хороо дүгнэлт хийх ач холбогдол багатай байна” гэжээ. Энд анхаарах зүйл бол 100 хувь хувьчлагдсан хувьцаат компанийн тухайд хувьцаа эзэмшигчид нь гэр бүл, ах дүүс байна гэдэг асуудал гаргах нь утгагүй зүйл. Харин хувь нийлүүлэгчдийн хурал нь зөвхөн саналын эрхийг хэрэгжүүлэх арга бус, олон нийтэд мэдээлэл хүргэх ач холбогдолтойгоос гадна хуульд заасан үүргээ биелүүлж байгаа хэрэг тул ач холбогдолгүй гэсэн дүгнэлт хийх нь өрөөсгөл байна.

Тайлбар
1.11-ийг
үзнэ үү

-Программ хангамж, мэдээллийн аюулгүй байдал: гэсэн хэсэгт Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ ХХК-д одоо ашиглагдаж байгаа программ хангамж, техникийн дутагдалтай байдлыг тусгасан ч оновчтой дүгнэлт хийгээгүй байна. Дээрх 2 байгууллагын ашиглаж байгаа “цогц” программ нь тухайн үед бирж дангаараа ашиглаж байсан, 2003 онд ҮЦТТХТ ХХК биржээс салснаас хойш 2 байгууллага хооронд мэдээллийн нууцлал алдагдах, бие биенээсээ программ хангамжийн ажилбарын хувьд хараат байх зэрэг нөхцөл одоо ч байсаар байна.

Хөрөнгийн биржийн арилжааны хяналтын программ хангалтгүй ажиллагаас биржийн үндсэн үүрэг болох арилжааны

Холбогдох байгууллагын санал

4

явцад үнэ ханшийг зохиомлоор өсгөх бууруулах, манмуулац хийхээс сэргийлэх хуулиар хүлээсэн үүрэг зөрчигдөх явдал гардаг. Мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж буй энэ үед тэр дундаа санхүүгийн зах зээлийн боловсронгуй хэлбэр болох ҮЦЗЗ-д ашиглагдаж буй программыг орчин үеийн үйлчилгээний шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай хэвээр байгаа болно.

-ҮЦТТТХТ ХХК-ийн үйлчилгээний онцлогт нийцүүлэн программ хангамжийг нь шинэчлэх, биржийн программтай уялдуулах зэрэг шаардлагууд байна.

Хорооны дарга С.Гүндэнбалд зөвлөсөн хэсэгт:

Хувьцааны төвлөрлийг зохистой түвшинд барих асуудлыг хөндөх боломжгүйн гадна хувьцаанд татвар ногдуулах гэдэг нь ойлгомжгүй байна. МХБ-ээс эрсдэлд оруулсан мөнгөний асуудлыг холбогдох газруудад тавьж Засгийн газрын шийдвэр гарсан бөгөөд уг шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал үлдээд байна.

Харин үнэт цаасны арилжаа явуулах биржтэй өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн альтернатив байгууллага бий болгох шаардлага байгаа юм. Энэ талаархи заалт Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмж орсон билээ




С.ГҮНДЭНБАЛ

Тайлбар
1.12-ыг
үзнэ үү

Холбогдох байгууллагын санал

МХБ ХК-
ийн
санал



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК

Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-2
Утас: 310501, 321411, Факс: (976)-11-325170
И-мэйл: mse@mongol.net, Вэб-сайт: www.mse.mn

2005-10-29 № 1/299
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б.БАТБАЯР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай 2005.10.18-ны өдрийн 282 тоот албан бичиг, Хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаа болон хөрөнгийн зах зээлийн төлөв байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.

Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит нь үнэт цаасны зах зээлийн хөгжил, өнөөгийн төлөв байдалд бодитойгоор хандаж, асуудал бүрийг олон талаас нь авч үзсэн, үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч, зохицуулагч, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, багагүй материал цуглуулсан, судалгаа дүгнэлт хийсэн сайн ажил болсон нь тайлангаас харагдаж байна.

Тайланд тусгагдсан асуудлууд, тухайлбал аудиторуудын гаргасан санал дүгнэлт, зөвлөмжүүдтэй санал нэгтэй байгаагаа илэрхийлэхийн дашрамд энэхүү тайланд дараах саналуудыг нэмж тусгавал үнэт цаасны зах зээлийн цаашдын хөгжилд илүү тус дөхөм болно гэж үзэж байна. Үүнд:

1. Төслийн 23 дугаар хуудасны “УИХ-ын анхааралд толилуулах” хэсэгт “Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг өргөжүүлж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох” санал дэвшүүлжээ. Энэ нь өргөн агуулгаараа үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох явдал бөгөөд энэ хүрээнд дараах 4 үндсэн асуудлыг хөндөх нь зүйтэй юм. Үүнд:

- УИХ-д хүргэгдээд байгаа “Төрөөс үнэт цаасны зах зээлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийг хэлэлцэн баталж, хэрэгжүүлж эхлэх,
- Одоогийн хууль тогтоомжийг боловсронгуй болгон, шинэчлэх,
- Зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийг шинээр батлан мөрдүүлэх,
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, хяналт тавих,

2. Мөн УИХ-ын анхааралд толилуулах дараагийн чухал сэдэв нь үнэт цаасны зах зээл хөгжих эдийн засгийн таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Тухайлбал:

- Төрийн мөнгөний бодлого, төсөв татварын оновчтой бодлогоор үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих,
- Үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал шаардлагатай хөрөнгө оруулалтын сан, андеррайтерийн компани, рейтингийн компани зэрэг

Тайлбар
2.1-ийг
үзнэ үү

Тайлбар
2.2-ыг үзнэ
үү

Холбогдох байгууллагын санал

Тайлбар
2.3-ыг үзнэ
үү

Тайлбар
2.4-ийг
үзнэ үү

- Үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал шаардлагатай хөрөнгө оруулалтын сан, андеррайтерийн компани, рейтингийн компани зэрэг мэргэжлийн байгууллагуудыг бий болгох асуудалд төрөөс онцгойлон анхаарах,
- Үнэт цаасны зах зээлээр дамжуулан хэрэгжүүлсэн өмч хувьчлалын үйл ажиллагааг дүгнэх улсын хэмжээний үзлэг зохион байгуулах, үнэт цаасны сонгомол зах зээлийн тухай ойлголтыг өмч хувьчлалын тухай ойлголтоос ялган салгах, сөрөг үр дагаврыг арилгах,
- Үнэт цаасны арилжааг сэргээн хөгжүүлэхэд саад болж буй арилжааны банкуудад алдагдсан харилцагчдын 653.0 сая төгрөгийн асуудлыг яаралтай шийдвэрлэх зэрэг асуудлууд багтаж байна.

3. Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоо, онцлог, дэлхийн бусад орнуудын хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан манай зах зээлийн өнөөгийн бүтэц тогтолцоог эргэж харах шаардлагатай байна. Ялангуяа үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн үйл ажиллагааг МХБ-ээс тусгаарлан бие даасан компани байгуулсаны зэрэг сөрөг үр дагаврыг дүгнэн цэгнэх цаг нэгэнт болжээ.

4. Эцэст нь үнэт цаасны зах зээлд оролцогч чухал субъектийн нэг болох хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг боловсрол, суурь ойлголтыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх, цаашид энэ зах зээл дээр ажиллах өндөр мэргэжлийн боловсон хүчинг шат дараатай бэлтгэх шаардлага тавигдаж байгаа талаар тайланд тусгах саналтай байна.




ГҮЙЦӨТГЭХ ЗАХИРАЛ

P.СОДХҮҮ

Холбогдох байгууллагын санал

ҮЦТТТХТ
ХХК-ний
ирүүлсэн
санал

Тайлбар
3.1-ийг
үзнэ үү


ҮЦТТТХТ
“ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК
“SECURITIES CLEARING HOUSE & CENTRAL
DEPOSITORY” Co., Ltd
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай-2
Утас: 313497, Факс: 976-11-324424
2005. 11. 01 № 1/502
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТИЙН ГАЗАРТ

Шалгалтын тайлангийн талаар

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хүсэлтээр тус газраас хийсэн аудитын тайлантай танилцлаа. Тайланд үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдлыг бүрэн хэмжээгээр тусгажээ. Тайланд тусгагдсан дүгнэлтүүдээс манай байгууллагатай холбоотой хэд хэдэн хэсэгт нэмэлт тайлбар өгөх нь зүйтэй гэж үзлээ.


1. Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

2002 онд батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д заасны дагуу МХБ ашгийн бус байгууллагыг үнэт цаасны арилжаа эрхлэх болон түүнтэй холбогдсон төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааг нь тусгаарлан 2 байгууллага болгосон байна хэмээсэн нь уг хуулийн заалтыг дутуу, өрөөсгөл тайлбарласан байна гэж үзэж байна. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд арилжаа эрхлэх байгууллага нь ганц байгаа үед дээрх хоёр байгууллага нэг байж болох юм. Гэтэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа өнөө үед энэхүү хууль нь үнэхээр цаг үеэ олсон, ирээдүйгээ харсан зөв алхам болсон.

Уг хуульд зааснаар үнэт цаасны арилжааг хөрөнгийн бирж болон дилерүүдийн арилжааны төв эрхлэхээр, харин үнэт цаасны арилжааны үр дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэдэг компани нь үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага байна гэж заасан. Мөн үнэт цаасны хадгаламжийн байгууллага нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэх, үнэт цаас хадгалах үйлчилгээг эрхлэх бөгөөд Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр төлбөр тооцооны үйлчилгээг хавсран үйлчлэх эрхтэй юм.

Байгууллагууд тусдаа үйл ажиллагаа явуулах болсноор үнэт цаасны зах зээлд тодорхой эерэг өөрчлөлтүүд гарч үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд ихээхэн ахиц гарсан. Санхүүгийн хувьд ч үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа бие даан ашигтай ажиллаж ирсэн.

Мөн үнэт цаас хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдлыг зах зээл хумигдсан, зогсонги байдалд орсон, иргэд зах зээлд итгэх итгэлгүй болсон зэргээр хэт өнгөц өрөөсгөл дүгнэжээ.



Холбогдох байгууллагын санал

Сүүлийн хагас жилд хөрөнгийн биржийн арилжаагаар хийгдсэн арилжааны дүн ч зах зээл харьцангуй сэргэж байгааг харуулж байна. Мөн энэхүү зах зээлд оролцогч иргэдийн хувьд итгэл алдарсан зүйл ажиглагдахгүй байна. Харин ч шинээр үнэт цаас гаргая, шинэ ямар үнэт цаас байна, мэдээллээ тодорхой өгөөч гэх хүсэлт олон болсон. Бүх нийтээр хувьцаа эзэмших, зах зээлд итгэх гэдэг угаасаа хаана ч байхгүй зүйл юм. АНУ-ын хүн амын 3 хувь нь л хувьцаа эзэмшдэг гэсэн тоо бий.

2. Бүртгэлтэй хувьцаат компаниудын тухай

Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн гэхээсээ илүү, Монгол Улсын эдийн засаг, зах зээлээс хамааралтайгаар хувьцаат компаниудын үйл ажиллагаа доголдох болсон. Нэг талдаа өмч эзэнгүйдэх, менежмент дутсанаас, өөрөөр хэлбэл хувьцааны зах зээлтэй холбоотойгоор компанийн үйл ажиллагаа алдагдах, нөгөө талдаа хэт хуучин технологи, зардал өртөг ихтэй үйлдвэрлэл, салбарын өрсөлдөөн, хөрөнгө оруулалт дутсанаас ихэнхи бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа зогссон байдаг. Байдал нэгэнт ийм байхад ашгийн тухай, ногдол ашгийн тухай бүр ярилтгүй байна.

Дүгнэлтэд энэ тухай дурдаад мөн хувьцаат компаниудын үйл ажиллагаанд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналт ор төдий болсон гэдэг нь үнэхээр зах зээлийн өнөөгийн байдлыг дүгнэх голыг нь олсон дүгнэлт болжээ.

3. Алдагдсан мөнгөний талаар

Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон тушаа болж байгаа нэг асуудал нь дампуурсан банкуудад байршиж байсан харилцагчдын мөнгөний асуудал байдаг. Дээрх мөнгийг харилцагчдад олгуулах, буруутай этгээдүүдээр шийдвэрлүүлэхээр холбогдох бүхий л газарт хандсан. Банкны өр барагдуулах алба, Улсын дээд шүүх, Монгол банк, Сангийн Яам гэдэг замаар бараг 8 жил хөөцөлдөж байгаа ч мухардалд ороод байна. Засгийн газраас гаргасан хэд хэдэн тогтоол, тэмдэглэл бий ч 2004 оноос хойш Сангийн Яам татгалзсан байр суурьтай байна.

4. Үнэт цаасны төлбөө тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамж сүлжээ нь өнөөгийн банк санхүүгийн зах зээлийн түвшинээс хоцронгуй явж байна. Программ хангамжийг боловсронгуй болгосноор зах зээлд гарах нааштай өөрчлөлтүүдийг харж болох ч хөрөнгө санхүүгийн хувьд энэ асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг уялдуулах шаардлага гараад байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ТУЯАЦЭЦЭГ



ҮАГ-ын тайлбар

1. Үнэт цаасны
хорооноос
ирүүлсэн
саналд өгөх
тайлбар

Тайлбар 1.1

Төрийн өмчийн хувьцаа, үнэт цаасыг худалдах үйл ажиллагааг ТӨХ гүйцэтгэж буй нь Үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлийн “ Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд нь андеррейтер, брокер, дилер, хөрөнгийн бирж түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, хөрөнгө оруулалтын сан байна”, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах Хөрөнгийн бирж, Дилерүүдийн арилжааны төв, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага, хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани байна” гэсэн заалтуудтай зөрчилдөж байгаа нь бодитой зүйл. Харин “Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаанд ТӨХ оролцож буй нь” гэснийг хасч залруулав.

Тайлбар 1.2

Компанийн тухай хууль хэрэгжиж ирсэн өнгөрсөн хугацаанд хувьцаа нэмж гаргах шийдвэрийг хуулийн дагуу цөөн тооны этгээдэд нэр заан олгож байсан болон нэмж гаргасан хувьцааг бирж дээр нээлттэй арилжиж жижиг хувьцаа эзэмшигчид авсан тохиолдол гараагүй нь хуулийн уг заалт жижиг хувьцаа эзэмшигчид нэмж гаргаж буй хувьцаанаас авах эрхийг боогдуулсан гэж үзэхэд хүргэж байна.

Тайлбар 1.3

Хуульд хэдийгээр ХК-иудад аудитор, ХШЗ-ийг сонгож ажиллуулах талаар заасан ч өнгөрсөн хугацаанд ХК-иуд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироож ирсэн тохиолдолуудад дээрх хяналтын механизм зохих ёсоор ажиллаагүй нь дүгнэлт зөв болохыг харуулж байна.

Тайлбар 1.4

Арилжаа хийгдэх процесс нь биржээс гадуур хийгдээд өнгөрсний дараа, нэгэнт арилжигдсан хувьцааг зөвхөн шилжүүлэх үйл ажиллагаа биржид явагдаж байгаа тул биржээр арилжаа явагдсан гэж үзэх үндэслэлгүй

ҮАГ-ын тайлбар

байна.

Тайлбар 1.5

Зах зээлийн нийгэмд төрөөс эдийн засагт татварын болон эдийн засгийн бусад аргаар, мөн хуулиар нөлөөлж бодлогоо хэрэгжүүлдэг нь өмчлөх эрхийг шууд хөндөж байгаа зүйл биш. Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал зогсонги байдалд орсон нь төрийн зохицуулалт зохих түвшинд хийгдээгүйг харуулж байна.

Тайлбар 1.6

Тайланд нэмэлт хувьцааг их гаргасан, хөрөнгийг дахин үнэлээгүй нь хууль зөрчсөн гэж бичээгүй, харин энэ нь бодит байдалд бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг үнэгүйдүүлж байгаа учир хуулийг боловронгуй болгох шаардлагатай гэж үзсэн болно.

Тайлбар 1.7

Хөрөнгийн биржээс бидэнд Алмааз ХК-ний талаар алдаатай мэдээлэл өгснийг танай саналын дагуу залруулж өөр компанийг жишээ болгон тайланд дурьдав.

Тайлбар 1.8

Үүнийг тайланд хууль зөрчсөн үйлдэл гэж үзээгүй хуулийн заалтыг өөрчлөх нь зүйтэй гэсэн утгаар тусгасан болно.

Тайлбар 1.9

Прокурорын шийдвэр гараагүй байсан 9 дүгээр сард аудитын тайлан бичигдэж дууссан байсан. Гэвч нэхэмжлэгчид уг асуудлаар давж заалдсан тул танай саналын дагуу залруулав.

Тайлбар 1.10

ХК-ийн хувьд хувь оролцооны дээрх байдал нь агуулгаараа ХХК-ны байдалтай болсон, ХХК-ны хувь нийлүүлэгчдийн хурлын материалыг Үнэт цаасны хороо авдаггүй нь ийм компаниудын хурлын материалыг Үнэт цаасны хороо авч дүгнэлт хийх нь ач холбогдол багатай гэж үзэхэд хүргэж байна.

Тайлбар 1.11

Энэ асуудлаар аудитын тайланд жишээ баримттайгаар тусгагдаж, дүгнэлт хийгдэн, сайжруулах талаар зөвлөмж өгөгдсөн болно.

Тайлбар 1.12

ҮАГ-ын тайлбар

ХК-иуд дахь олон зуун тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах эрх мянга гаруй иргэд буюу хэдхэн зуун гэр бүлийн гарт төвлөрсөн ба эдгээр хөрөнгөнд ногдох үл хөдлөх хөрөнгийн татвар төлөх болохоор компаниас буюу бусад хувьцаа эзэмшигчдийн мөнгөнөөс төлчихөөд, ногдол ашиг өгөхгүй байгаа нь шударга бус юм. Иймд хувьцаанд татвар ногдуулах нь энэ шударга бус байдлыг арилгахаас гадна, хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг өндөржүүлж хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Тайлбар 2.1

Саналд дурьдсан төсөлтэй танилцаж дүгнэлт хийгээгүй учир ийм зөвлөмж өгөх боломжгүй бөгөөд бусад асуудал аудитын тайланд тусгагдсан болно.

Тайлбар 2.2

Эдгээр асуудалыг ҮЦХ-д зөвлөмж болгосон.

Тайлбар 2.3

Аудитын зорилт, тайланд тусгагдаагүй асуудал тул зөвлөмжид оруулах боломжгүй.

Тайлбар 2.4

Сурталчилгааны асуудалыг ҮЦХ-д зөвлөмж болгосон бөгөөд аудитын зорилтод заагаагүй, тайланд ороогүй учир “Цаашид энэ зах зээл дээр ажиллах өндөр мэргэжлийн боловсон хүчинг шат дараатай бэлтгэх шаардлага тавигдаж байгаа” талаар тусгах боломжгүй.

Тайлбар 3.1

Аудитын тайланд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн заалтыг тайлбарласан бус, Хөрөнгийн биржийг хоёр компани болгосон тухай дурьдсан болно. Хөрөнгийн зах зээл зогсонги байдалд орсон нь аудитын дүнгээр нотлогдсон асуудал юм.

2.МХБ ХК-иас
ирүүлсэн
саналд өгөх
тайлбар

3.ҮЦТТТХТ ХХК-
иас ирүүлсэн
саналд өгөх
тайлбар

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5 "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Улсын Их хурлын Эдийн засгийн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн төлөв байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр.Гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Монгол Улсын Үнэт цаасны хороо, Монголын хөрөнгийн бирж ХК, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д хүргүүлсүгэй.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2006 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Монгол Улсын Үнэт цаасны хорооны дарга С.Гүндэнбал, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Содхүү, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Туяацэцэг нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын хоёрдугаар хэлтсийн дарга О.Мэндбаярт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР  Л.ЖАВЗМАА